



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 5/02

Эрдэнэт

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.5.3 заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай” /нэг өрх-нэг ажлын байр/ аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, нарийвчилсан төлөвлөгөө баталж ажиллах, биелэлтийн явцыг жил бүрийн I улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

3. Энэ хөтөлбөрийн хүрээнд өөрт хамаарах зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ талаар зохион байгуулагдаж буй арга хэмжээнд идэвхитэй оролцож хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг нийт иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.

ДАРГА



П. ПҮРЭВЛХАГВА